



**“БУЛИГААР” ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

<i>Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт I/</i>	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Булигаар” ХК РД:2039184 MSE: MBG Утас: 99626299 И-мэйл: info@buligaar.com Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг 17042, Чингисийн өргөн чөлөө, АШУ-н хашаа
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Арьс шир боловсруулалт Гутлын дээд биеийн материал үйлдвэрлэх Худалдаа Худалдааны зуучлал Гадаад худалдаа
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	“Сэрэлт дөл аудит” ХХК 2019-08-28
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	400,212,000
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч Г.Сэлэнгэ ТУЗ-ийн нарийн бичиг Г.Цээпилжид Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг
1. Тайлант жилийн санхүүгийн тайлан <i>/хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>	
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн: 14,199,458,819.49 Эргэлтийн бус хөрөнгийн дүн: 18,247,864,245.13 Нийт хөрөнгийн дүн: 32,447,323,064.62 Өр төлбөрийн нийт дүн: 21,472,058,808.38 Эздийн өмчийн дүн: 10,975,264,256.24 Өр төлбөр ба эздийн өмчийн дүн: 32,447,323,064.62
	Орлогын тайлан

		Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-94,336.49
		Татвар төлөхийн өмнөх ашиг:	105,920,966.98
		Орлогын татварын зардал:	10,409,811.12
		Тайлант үеийн цэвэр ашиг:	95,511,155.86
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл:	6,473,162,300
		2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл:	11,727,544,902.86
		2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл:	11,662,764,191.94
		2024 оны тайлант үеийн цэвэр ашиг:	95,511,155.86
		2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл:	12,966,912,72.75
	Мөнгөн гүйлгээний тайлан	Мөнгөн орлогын дүн:	12,297,336,820.62
		Мөнгөн зарлагын дүн:	8,542,568,865.60
		Үндсэн үйл ажиллагааны Мөнгөн гүйлгээ:	3,754,767,955.02
		Мөнгөн орлогын дүн:	57,710.30
		Мөнгөн зарлагын дүн:	334,293
		260,15	
		Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн:	-334,235,749.85
		Мөнгөн орлогын дүн:	1,793,935,000.00
		Мөнгөн зарлагын дүн:	5,219,330,998.48
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн:	-3,425,395,998.48
		Валютын хашийн зөрүү:	-3,868,196.44
		Цэвэр мөнгөн гүйлгээ:	-8,731,989.75
		Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл:	22,914,287.62
		Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл:	14,182,297.87
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт		
	“Сэрэлт дөл аудит” ХХК нь “Булигаар” ХК-ийн 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ. Дүгнэлтээр, санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн МУ-ын Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.		
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/		
	Энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.		

2.


Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл

Санхүүгийн үзүүлэлтүүд

БУЛИГААР ХК 2024 ОН
/2023 оны гүйцэтгэлтэй харьцуулав/




Нийт борлуулалтын орлого



Нийт хөрөнгө



Цэвэр ашиг (алдагдал)



Нийт борлуулалтад гадаад борлуулалтын эзлэх хувь

2021 оноос эхлэн гадаад зах зээл рүү борлуулалт хийж эхэлснээр:

- 2021 онд нийт борлуулалтын 8.6%
- 2022 онд нийт борлуулалтын 21%-ийг
- 2023 онд нийт борлуулалтын 19%-ийг
- 2024 онд нийт борлуулалтын 14%-ийг тус тус бүрдүүлэх болсон.



2.1.

Үйл ажиллагааны үр дүн

		<h3 style="text-align: center;">Хөрөнгө оруулалт</h3> <div style="text-align: center;"> <p> ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ 92.7% БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ 7.3% БУСАД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 0% </p> </div> <div style="border: 1px solid #ccc; padding: 5px; margin-top: 10px;"> <p>2021 онд 548,143,363 төгрөгийн хөрөнгө оруулалт 2022 онд 1,682,654,545 төгрөгийн хөрөнгө оруулалт 2023 онд 299,847,741 төгрөгийн хөрөнгө оруулалт 2024 онд 653,148,266 төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийсэн.</p> </div>
2.2.	<p><i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i></p>	<p>Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 0.29%</p> <p>Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 95.5%</p> <p>Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/</p> <p>Нийт активын өөрчлөлт 95.5 %</p> <p>Зээлийн багцын өөрчлөлт 66.1%</p> <p>Хөрөнгөд эзлэх хувь</p> <p>Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө 0.3%</p> <p>Өр төлбөр /Нийт хөрөнгө 66.1%</p> <p>Хөрвөх чадварын харьцаа</p> <p>Хөрвөх чадварын хөрөнгө/ 43.7%</p> <p>Татан төвлөрүүлсэн хөрөнгө</p>
2.3	<p><i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i></p>	<p>ТУЗ-ийн баталсан 2024 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилт нь компанийн борлуулалтын орлогыг өмнөх оноос 54% өсгөх, ашигт ажиллагааг сайжруулан ашгийн түвшинг нэмэгдүүлэх, дотоод борлуулалтын сувгийг нэмэгдүүлэн харилцагчид илүү ойртож ажиллах, хүний нөөцийн тогтвортой бодлогыг баримтлан ажиллах, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг сайжруулах зэрэгт тус тус чиглэсэн.</p> <ul style="list-style-type: none"> • 2024 онд санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн хувьд 11 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй байснаас бодит гүйцэтгэлээр 8,628.3 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөөг 78%-ийн биелэлтэй ханган ажиллаж, өмнөх оноос мөн үеэс 19.7%-ийн өсөлтийг үзүүлжээ. • Монгол Улс дахь дотоод борлуулалт өмнөх оны мөн үеэс 28%-ийн өсөлтийг үзүүлсэн. • Гадаад борлуулалт буюу экспортын хэмжээ өмнөх оны үзүүлэлтээс 8% буурсан байна. Манай голлох экспортлогч маш их мөнгөний ханшны уналт, мөн дайны замын нөхцөл байдлаас холбогдон эрсдэл хаа хаанаа гарахаас сэргийлж борлуулалт хийгдэхгүй байгаа. • Арьс ширний үйлдвэрүүдийг шинэ суурьшлын бүс болох эмээлт рүү нүүлгэх төрийн бодлогын чиглэл хандлага тодорхой болсон. • Ижил төрлийн бүтээгдэхүүний хяналтгүй импортын эсрэг үйлдвэрлэлийн технологийг тогтвортой байлгах, шинэчлэлт хийх бодлого барьж ажиллаж байгаа.

		<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн болон менежментийн ур чадвар бүхий ажиллах хүчний тасалдал бий болсон төдийгүй энэ байдал цаашид үргэлжлэх хандлагатай байна. Энэхүү асуудал нь салбар төдийгүй улсын хэмжээнд яригдах болсон. <p>Булигаар компанийн хувьд 2024 онд 95 мянга гаруй үхрийн шир, 267 мянган ямааны арьсыг хагас болон гүн боловсруулан дотоод гадаадын зах зээлд нийлүүлсэн байна.</p> <p>2024 онд нийт хөрөнгө оруулалтын 92.7%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжид, 7.3%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалтад зарцуулсан байна.</p> <p>Бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, шинэ технологи, арга барилыг байнга нэвтрүүлэн ашигладаг бөгөөд хуучин технологио эрчим хүч, зардал бага зарцуулдаг орчин үеийн тоног төхөөрөмжөөр шинэчлэх хөрөнгө оруулалтыг тасралтгүй хийсээр байна. Энэхүү ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэн боловсруулах цехэд БНТУ-ын Demaksan компанитай хамтран хоёр шүрших машины толгойг шинэчлэн суурилуулсан. Хуучны рамыг шинэчлэн 16 буутай шүрших шугам болгон зассан мөн зааланд байдаг төхөөрөмжийн 2 дахь толгойг 12 буутайгаар засаж шинэчлэн одоо ашиглалтад ороод хэвийн ажиллаж байгаа. - Түүнчлэн Demaksan компаниас талбай хэмжих машиныг илүү сайжруулж эцсийн бараан дээр гарах дм.кв-ийн штамп, эцсийн бараан дээр наалдаж явдаг дм.кв-ийн мэдээлэл зэрэг дээр шинэчлэлт хийгдсэн. - Элэгдэл насжилт арай өндөртэй байсан химийн боловсруулах цехийн шахах машиныг сольж Солонгос улсын Rotoria брэндийн шахах машиныг шинээр суурилуулсан. Энэ хоёр хөрөнгө оруулалтаас бусад хөрөнгө оруулалт нь ерөнхийдөө барилга байгууламж мөн цэвэрлэх байгууламж дээр зарим тоног төхөөрөмжүүдийг сэлбэж засварласан байна. <p>Ирж буй 2025 ондоо хүний нөөцийн чадавхыг улам бүр сайжруулах чиглэлд анхаарч мэдлэг ур чадварт тулгуурласан бүтээлч хамт олны соёлыг цогцлоож салбарын тэргүүлэгч үйлдвэрүүд болохыг зорин ажиллаж байна.</p>
2.4.	<p><i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх</i></p>	<p>Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.</p>
2.5.	<p><i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i></p>	<p>2024.12.31-ний өдрийн байдлаар Капитрон банкнаас авсан зээлийн барьцаанд компанийн үл хөдлөх хөрөнгө болон газрыг тус тус барьцаасан байгаа. Зээлийн эргэн төлөлт хэвийн явагдаж байгаа болно.</p>
3.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
		<p>Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.</p>

4.

Цалин урамшууллын мэдээлэл**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ****ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал**

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооноос тодорхойлон санал боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг. Сүүлийн хэдэн жил ТУЗ-ийн ердийн гишүүдэд цалин олгохгүй бөгөөд хараат бус гишүүдийн цалин нь хурлын оролцоонд үндэслэсэн цалинтай байдаг. 2024 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалингийн хэмжээг дараах байдлаар тогтоосон.

ТУЗ-ийн хараат бус гишүүдэд олгох оролцоонд суурилсан цалин

ТУЗ-ийн хурал,
Хувьцаа эзэмшигчдийн хурал,
ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоо тутамд
250,000 төг

<i>ТУЗ-ийн цалин урамшуулал</i>	<i>2023 он</i>		<i>2024 он</i>	
	<i>Гүйцэтгэл</i>	<i>Төлөвлөгөө</i>	<i>Гүйцэтгэл</i>	<i>Төлөвлөгөө</i>
Оролцооны цалин	4,500,000	7,500,000	7,500,000	7,500,000
Нийт дүн	4,500,000	7,500,000	7,500,000	7,500,000

2024.04-2025.04 хүртэлх хугацаанд ТУЗ-ийн хараат бус гишүүдэд 7.5 сая төгрөгийн цалинг олгох байгаа.

Компанийн гүйцэтгэх удирдлагын цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг ТУЗ-аас гүйцэтгэх удирдлагатай байгуулах “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний холбогдох заалтад тусгасан байгаа.

Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг бөгөөд цалин урамшуулал нь компанийн санхүү, үйл ажиллагааны үр дүн болон ажлын гүйцэтгэлтэй уялдсан байх бөгөөд цалин, урамшууллын хэмжээ, түүнийг олгох зарчмыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо тогтоодог. Тус компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Б.Анхболдод 2024.04.21-ний өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэх захирлаар ажиллах хугацаанд компаниас цалин, урамшуулал олгоогүй болно. 2024 оны 4-р сард ТУЗ-өөс шинээр томилогдсон Гүйцэтгэх захиралтай “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г шинэчлэн байгуулсан.

Менежментийн багийн удирдлагуудын цалин, урамшуулал

Гүйцэтгэх захирлаас бусад менежментийн багийн удирдлагуудын цалин, урамшуулал, түүнийг олгох шалгуур үзүүлэлтийг Цалин, урамшууллын бодлогын хүрээнд Гүйцэтгэх захирал тогтоодог.

Цалингийн бүтэц: Үндсэн цалин + Гүйцэтгэлд суурилсан цалин

<i>Менежментийн багийн цалин урамшуулал</i>	<i>/мянга.төг/</i>		
	<i>2023 он</i>	<i>2024 он</i>	<i>Өөрчлөлт</i>
Үндсэн цалин	70,130	84,957	21%
Гүйцэтгэлд суурилсан цалин	3,065	11,075	261%
НДШ	8,417	11,043	31%
Нийт дүн	81,613	107,075	31%

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

2024 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛ

Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 14:00 цагт ХУД-ийн 20-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав.

Хурлын ирц: Хуралд 88.16 хувийн саналын эрхтэй нийт 6 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан.

Хурлаар танилцуулан хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.
- Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг танилцуулав.
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн Булигаар ХК-ийн 2023 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд “сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгснийг 99.9%-ийн саналаар батлав.
- Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулав.
- 2022 оны ногдол ашиг тараалтын тухай болон 2023 онд ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн гаргасан тогтоолыг танилцуулав.
- ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулав.
- ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв танилцуулж, 100%-ийн саналаар батлав.
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг танилцуулан, ТУЗ-ийн гишүүдийг 1 жилийн хугацаагаар сонгов.



ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат танилцуулав.



Компанийн аудитын тайланг “Сэрэлт дөл аудит” ХХК-ийн аудитор Д.Алтанцэцэг танилцуулав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2024 оны 7-р сарын 19-ний өдөр 14:00 цагт ХУД-ийн 20-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав.

Хурлын ирц: Хуралд 51.63 хувийн саналын эрхтэй нийт 4 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан.

Хурлаар танилцуулан хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр

- Булигаар ХК-ийн үл хөдлөх хөрөнгө болон газрыг зээлийн гэрээний барьцаанд тавих эрх олгох асуудлыг танилцуулж, 100%-ийн саналаар батлав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлаар 1 жилийн хугацаагаар сонгогдсон бөгөөд тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллав. Үүнд:

- *Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:* Жадамбын Эрдэнэбат, Төмөрбаатарын Болд, Чулуунбаатарын Нямдорж
- *Төлөөлөн Удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:* Батчулууны Анхболд, Анхболдын Энхмэнд, Батчулууны Баянжаргал, Довжидын Гансүх, Бямбабаярын Баттүшиг, Цэрэндагвын Мөнхлхагва

“Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар ханган, компанийн стратегийн зорилтот түвшин, санхүү эдийн засгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөг батлан, холбогдох чиг үүрэг, зөвлөмжүүдийг өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороог ажиллуулж, засаглалын болон дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан, ирц: ТУЗ-ийн дэргэд 3 хороо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ТУЗ-ийн ээлжит хурал улирал тутам, хороод жилд 2 удаа ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТУЗ-ийн зүгээс компанийн удирдлагуудад санал, зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг.

ТУЗ нь 2024 оны тайлант хугацаанд нийт 10 удаа хуралдсан ба үүнээс цахимаар 5 удаа, биечлэн 3 удаа, эчнээ хэлбэрээр 2 удаа хуралдаж, нийт 17 асуудалд үнэлэлт, дүгнэлт өгч, 15 тогтоолоор шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.

ТУЗ БОЛОН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ХУРАЛДААН

<i>Хурал</i>	<i>Ээлжит хурал</i>	<i>Ээлжит бус хурал</i>	<i>Хэлэлцсэн асуудал</i>	<i>Шийдвэр</i>	<i>Санал зөвлөмж</i>	<i>Баталсан тогтоол</i>
ТУЗ-ийн хурал	3	6	17	15	1	15
Аудитын хороо	2	2	4	3	1	3
Цалин урамшууллын хороо	1		2	1		1
Нэр дэвшүүлэх хороо	1	1	2	1	1	1
Нийт	7	9	25	20	3	20

ХУРЛЫН ИРЦ

ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн хурлын мэдээллийг цаг тухай бүрд нь и-мэйлээр хүлээн авч, биечлэн оролцох боломжгүй тохиолдолд саналаа цахим шуудангаар урьдчилан илгээдэг. Ийм тохиолдол цөөн бөгөөд хурлын ирцийг оролцсоноор тооцдог.

<i>ТУЗ-ийн гишүүний нэр</i>	<i>ТУЗ-ийн хорооны харьяалал</i>	<i>ТУЗ-ийн хурлын ирц</i>	<i>ТУЗ-ийн Хорооны ирц</i>
Т.Болд	Нэр дэвшүүлэх хорооны дарга Аудитын хорооны гишүүн	100%	100%
Ч.Нямдорж	Аудитын хорооны дарга	100%	100%
Ж.Эрдэнэбат	Цалин урамшууллын хорооны дарга	100%	100%
Б.Баянжаргал	Цалин урамшууллын хорооны гишүүн	100%	100%
Б.Баттүшиг	Цалин урамшууллын хорооны гишүүн	100%	100%
Д.Гансүх	Цалин урамшууллын хорооны гишүүн	100%	100%
Б.Анхболд	Аудитын хорооны гишүүн	100%	100%
А.Энхмэнд	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%
Ц.Мөнхлхагва	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%

ТУЗ-ИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭР

Тайлант хугацаанд ТУЗ нь хороодын оруулж ирсэн санал, дүгнэлтийн дагуу дараах хэлэлцэх асуудлын хүрээнд ээлжит болон ээлжит бус хурлыг 10 удаа зохион байгуулсан. Тус хугацаанд нийт 15 тогтоол баталсан.

- Ногдол ашиг тараах
- 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагаа санхүүгийн тайланг хэлэлцэн дүгнэх
- Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох;
- Эрх олгох тухай;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх;
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэгчийн талаар
- ТУЗ-ийн цалин урамшуулал, зардлын талаар
- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг байгуулах тухай;
- Гүйцэтгэх захирал томилох тухай;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх;
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам батлах тухай;
- Комплайнсын ажилтан томилох тухай;

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх, Аудитын хороодын хурлаас 6 дүгнэлт шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Компани нь сайн засаглалын туршлагаудаас суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээллээр ханган, санал хүсэлт, асуултад тухай бүр хариу өгч байгаа. Энэхүү зарчмын хүрээнд 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичиг бүхий тараах материалыг 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн дотор үнэт цаасны брокер, дилерийн компаниудад цахимаар хүргүүлсэн.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2024 онд ТУЗ-ийн үйл ажиллагаанд 13,596,700 төгрөгийн зардал (2024.04.19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03/24 тоот тогтоол) төсөвлөж, гүйцэтгэл 14,033,800 төгрөг буюу 84%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2024 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл дараах хүснэгтээс үзнэ үү.

Зардлын төрөл	2023 он		2024 он	
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө
ТУЗ-ийн цалин урамшуулал	4,500,000	7,500,000	4,500,000	7,500,000
ХЭ-ийн хурлын зардал	1,702,100	2,121,700	1,702,100	2,121,700
Бусад зардал /Үйлчилгээний хураамж/	4,814,250	7,000,000	4,814,250	7,000,000
Нийт дүн	11,016,350	16,621,700	11,016,350	16,621,700

Жич: Энэхүү төсөв нь 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараа жилийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хамаарна.

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТ

ТУЗ-ийн 2024.04.19-ний өдрийн № 10/24 тоот тогтоолоор Гүйцэтгэх захирал Б.Анхболдыг өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлж, 2024.04.22-ны өдрөөс эхлэн Булигаар ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Б.Баттүшигийг томилохоор шийдвэрлэсэн. Тэрээр БНТУ-ын ЭГЭ их сургуулийг арьс шир боловсруулах инженер мэргэжлээр төгсөн бөгөөд Монгол Шевро ХК-д технологич, Булигаар ХК-д технологичийн албан тушаалыг тус тус хашиж байсан туршлагатай.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын багийг удирдан ажилладаг. Тайлант хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн:

- Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг
Булигаар ХК-д ажиллаж буй хугацаа: 6 жил
Булигаар ХК-ийн хувьцааны эзэмшил: 0.002%
- Ерөнхий нягтлан бодогч Г.Сэлэнгэ
Булигаар ХК-д ажиллаж буй хугацаа: 7 сар
Булигаар ХК-ийн хувьцааны эзэмшил: Хувьцаа эзэмшдэггүй.

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД

1. Жадамба ЭРДЭНЭБАТ

Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
1	МУИС	Улаанбаатар	1987	1992	Математикч

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	0630111	2013/03	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	МУИС, ТИС	Багш	1992 - 1996
2	Ноён суудал брокерын пүүс	Гүйцэтгэх захирал	1996 - 2001
3	Ханын материал ХК	Санхүү эрхэлсэн захирал	2002 - 2004
4	Хөдөө аж ахуйн бирж	Гүйцэтгэх захирал	2013 - 2016
5	Монголын Үнэт цаасны бирж	Гүйцэтгэх захирал	2017 - 2020
6	Эрдэс баялгийн бирж	Гүйцэтгэх захирал	2020 - 2022
7	Булигаар ХК	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2022 - одоо
8	Тэргэл менежмент ХХК	Шинжээч ажилтан	2022 - одоо

2. Төмөрбаатар БОЛД

Боловсролын талаарх мэдээлэл

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
1	ЗХУ Украин Машин байгууламжийн дээд	Луганск хот	1987	1992	Инженер

Мэргэжил дээшлүүлсэн байдал

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	0430482	2017/03	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Монголын хөрөнгийн бирж	Хяналтын ажилтан	1992 - 1995
2	Дэлгэрхангай брокерийн пүүс	брокер	1995 – одоо
3	Даац инвестмент ХХК	Гүйцэтгэх захирал	2017 – одоо
4	Монголын Үнэт цаасны бирж	ТУЗ-ийн ердийн гишүүн	2017 – одоо
5	Тэлмэн групп ХХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2021 - одоо
6	Булигаар ХК	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2022 - одоо

3. Чулуунбаатар НЯМДОРЖ					
Боловсролын талаарх мэдээлэл					
№	Төгссөн сургууль	Байршил	Элсэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
1	ХААИС	Улаанбаатар	1988	1992	ХАА-н нягтлан бодогч эдийн засагч
2	МУИС	Улаанбаатар	1997	2000	Эрх зүйч
3	ХААИС	Улаанбаатар	2003	2003	Бизнесийн удирдлагын магистр
Мэргэжил дээшлүүлсэн байдал					
№	Сургууль, дамжаа, курс		Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв		0430968	2022/03	Компанийн засаглал
Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл					
№	Ажилласан байгууллагын нэр		Албан тушаал		Ажилласан хугацаа
1	ШУА-ын харьяа ХАА-н Эдийн засгийн хүрээлэн		Эрдэм шинжилгээний ажилтан		1992 - 1993
2	Чингэлтэй дүүргийн Татварын алба		ТУБ		1993 - 1995
3	Төрийн хянан шалгах хороо, Нийслэлийн аудитын газар		Хянан байцаагч, ахлах хянан байцаагч, ахлах шинжээч		1995 - 2014
4	Одбүртгэл аудит болон Мүүрь Аудит ХХК		Мэргэжлийн үйлчилгээ хариуцсан дэд захирал		2014 - 2020
5	Тэргэл менежмент ХХК		Гүйцэтгэх захирал		2021 - одоо
6	Булигаар ХК		ТУЗ-ийн хараат бус гишүүн		2022 - одоо
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮД					
4. Батчулуун АНХБОЛД					
Боловсролын талаарх мэдээлэл					
№	Төгссөн сургууль	Байршил	Элсэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил
1	Монгол Улсын Их сургууль	Улаанбаатар	1995	1996	Мэдээлэл зүйн магистр
2	Монгол Улсын Их сургууль	Улаанбаатар	1990	1994	Худалдааны эдийн засагч
Мэргэжил дээшлүүлсэн байдал					
№	Сургууль, дамжаа, курс		Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын үндэсний төв		0730592	2016/03	Компанийн засаглал
Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл					
№	Ажилласан байгууллагын нэр		Албан тушаал		Ажилласан хугацаа
1	Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн сургууль		Мэдээлэл зүйн багш		1994 - 1996
2	Санком ҮЦК ХХК		Диллер		1998 - 2000
3	Дархан Минж ХХК		Ерөнхий захирал, Гүйцэтгэх захирал		2001 - 2018
4	Булигаар ХК		Гүйцэтгэх захирал		2019 - 2024
5	Булигаар ХК		ТУЗ-ийн ердийн гишүүн		2019 - одоо

4. Батчулуун БАЯНЖАРГАЛ

Боловсролын талаарх мэдээлэл

<i>№</i>	<i>Төгссөн сургууль</i>	<i>Байршил</i>	<i>Элссэн он</i>	<i>Төгссөн он</i>	<i>Эзэмшсэн мэргэжил</i>
1	Монгол Улсын Их сургууль	Улаанбаатар	1996	2000	Эдийн засагч

Мэргэжил дээшлүүлсэн байдал

<i>№</i>	<i>Сургууль, дамжаа, курс</i>	<i>Дугаар</i>	<i>Огноо</i>	<i>Чиглэл</i>
1	Компанийн засаглалын үндэсний төв	0230359	2019/06	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

<i>№</i>	<i>Ажилласан байгууллагын нэр</i>	<i>Албан тушаал</i>	<i>Ажилласан хугацаа</i>
1	Монгол шуудан банк	Нягтлан бодогч	2000 - 2006
2	Дархан Минж ХХК	Гүйцэтгэх захирал, дэд захирал	2006 - одоо
3	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2019 - одоо

5. Анхболд ЭНХМЭНД

Боловсролын талаарх мэдээлэл

<i>№</i>	<i>Төгссөн сургууль</i>	<i>Байршил</i>	<i>Элссэн он</i>	<i>Төгссөн он</i>	<i>Эзэмшсэн мэргэжил</i>
1	Вестминстерийн Их сургууль	ИБУИНВУлс, Лондон хот	2013	2016	Хөрөнгө оруулалтын Санхүүч

Мэргэжил дээшлүүлсэн байдал

<i>№</i>	<i>Сургууль, дамжаа, курс</i>	<i>Дугаар</i>	<i>Огноо</i>	<i>Чиглэл</i>
1	Компанийн засаглалын үндэсний төв	0230359	2019/06	Компанийн засаглал
2	Санхүүгийн зохицуулах хороо		2018	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл

<i>№</i>	<i>Ажилласан байгууллагын нэр</i>	<i>Албан тушаал</i>	<i>Ажилласан хугацаа</i>
1	Монголын үнэт цаасны бирж ХХК	Төлбөр тооцооны ахлах ажилтан	2016 - 2017
2	Ард секюритиз УЦК ХХК	Хөрөнгө оруулалтын аналит	2017
3	Монгол шир төсөл, Парк таун бонд	Санхүүгийн зөвлөх	2018
4	Екап ХХК	Үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулалт хариуцсан захирал	2018 - 2019
5	Булигаар ХК	ТУЗ-ийн дарга	2019 - одоо
6	Лугати ХХК	Гүйцэтгэх захирал	2020 - 2022
7	Мөнх Орших Капитал ББСБ	Гүйцэтгэх захирал	2021 - 2022
8	Алтан Хоромсог УЦК ХХК	Гүйцэтгэх захирал	2022 - одоо

7. Довжид ГАНСҮХ

Боловсролын талаарх мэдээлэл

<i>№</i>	<i>Төгссөн сургууль</i>	<i>Байршил</i>	<i>Элссэн он</i>	<i>Төгссөн он</i>	<i>Эзэмшсэн мэргэжил</i>
1	Барилгын Их Сургууль	ОХУ Эрхүү хот	1986	1991	Барилгын технологич

Мэргэжил дээшлүүлсэн байдал

<i>№</i>	<i>Сургууль, дамжаа, курс</i>	<i>Дугаар</i>	<i>Огноо</i>	<i>Чиглэл</i>
1	Компанийн засаглалын үндэсний төв	0230360	2019/06	Компанийн засаглал

Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл					
<i>№</i>	<i>Ажилласан байгууллагын нэр</i>	<i>Албан тушаал</i>	<i>Ажилласан хугацаа</i>		
1	ТТҮБ траст ХХК	Барилгын даамал	1993 - 1995		
2	Зэндмэнэ инвест ХХК	Захирал	1995 - 2004		
3	Дархан Минж ХХК	Үйлдвэрлэл хариуцсан захирал, Үйлдвэрлэлийн менежер	2004 - 2013		
4	Сүлд Ивээл Констракшн ХХК	Захирал	2014 - 2018		
5	Булигаар ХК	Үйлдвэрлэл хариуцсан захирал	2019 - 2024		
6	Нихон инвест ХХК	Гүйцэтгэх захирал	2024 - одоо		
7	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2019 - одоо		
8. Бямбабаяр БАТТУШИГ					
Боловсролын талаарх мэдээлэл					
<i>№</i>	<i>Төгссөн сургууль</i>	<i>Байршил</i>	<i>Элссэн он</i>	<i>Төгсөн он</i>	<i>Эзэмшсэн мэргэжил</i>
1	Ege University	БНТУ	2012	2016	Арьс шир боловсруулах инженер
2	СЭЗИС	Улаанбаатар	2016	2018	Санхүүгийн удирдлагаар магистр
Мэргэжил дээшлүүлсэн байдал					
<i>№</i>	<i>Сургууль, дамжаа, курс</i>	<i>Дугаар</i>	<i>Огноо</i>	<i>Чиглэл</i>	
1	Компанийн засаглалын хөгжлийн үндэсний төв	0132257	2023/03	Компанийн засаглал	
Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл					
<i>№</i>	<i>Ажилласан байгууллагын нэр</i>	<i>Албан тушаал</i>	<i>Ажилласан хугацаа</i>		
1	Монгол Шевро ХК	Технологич	2016 - 2019		
2	Булигаар ХК	Технологич	2019 - 2024		
3	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2023 - одоо		
4	Булигаар ХК	Гүйцэтгэх захирал	2024 - одоо		
7. Цэрэндагва МӨНХЛХАГВА					
Боловсролын талаарх мэдээлэл					
<i>№</i>	<i>Төгссөн сургууль</i>	<i>Байршил</i>	<i>Элссэн он</i>	<i>Төгсөн он</i>	<i>Эзэмшсэн мэргэжил</i>
1	ШУТИС, КТМС	Улаанбаатар	2001	2005	Бизнесийн удирдлага
2	ШУТИС, КТМС	Улаанбаатар	2006	2007	Хүний нөөцийн менежментээр магистр
Мэргэжил дээшлүүлсэн байдал					
<i>№</i>	<i>Сургууль, дамжаа, курс</i>	<i>Дугаар</i>	<i>Огноо</i>	<i>Чиглэл</i>	
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	0131897	2022/03	Компанийн засаглал	
Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл					
<i>№</i>	<i>Ажилласан байгууллагын нэр</i>	<i>Албан тушаал</i>	<i>Ажилласан хугацаа</i>		
1	МАТ ХХК	Менежер	2005 - 2007		
2	Гангар Инвест ХХК	Хүний нөөцийн менежер	2007 - 2008		
3	Алтайн Хүдэр ХХК	Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн, хэлтсийн захирал	2008 - 2016		
4	ТМГрупп ХХК	Хүний нөөцийн зөвлөх	2016 - 2018		
5	Булигаар ХК	Хүний нөөцийн ахлах менежер	2019 - одоо		
6	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2022 - одоо		

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

“Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсан дагуу Булигаар ХК-ийн ТУЗ-ийн 2022.05.06-ны өдрийн №11/22 тоот тогтоолоор Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд үе шаттайгаар компанийн засаглалын бодлого, дүрэм журмуудыг кодекст нийцүүлэн дүрэм журмуудыг шинээр болон шинэчлэн баталж дуусгав.

“Булигаар” ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлгээний дүнг 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороо хянан баталгаажуулсан болно. Тус компанийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар 88.2% буюу дунд засаглалтай гэж үнэлэгдсэн нь 2023 оны жилийн эцсийн үнэлгээнээс 29.7%-иар өссөн үзүүлэлт байна. 2023 оны жилийн эцсийн үнэлгээгээр Монгол улс дахь нээлттэй хувьцаат компаниудын 49-д эрэмбэлэгдэж хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй түвшинд байсан бол 2024 оны эхний хагас жилээр Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч топ 20 компаниудын эгнээнд багтаж чадлаа.

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	2023.12.31		2024.06.30	
			СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээний хувь	СЗХ-ны хяналтын оноо	Үнэлгээний хувь
1.	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	6	50.0%	11	91.7%
2.	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7	70.0%	10	100.0%
3.	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	2	33.3%	4	66.7%
4.	Аудит, хяналтын тогтолцоо	6	4	66.7%	5	83.3%
5.	Эрсдэлийн удирдлага	8	6	75.0%	7	87.5%
6.	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	66.7%	6	100.0%
7.	Оролцогч талуудын эрх ашиг	8	2	25.0%	6	75.0%
8.	Компанийн соёл	6	6	100.0%	6	100.0%
9.	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	4	40.0%	9	90.0%

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

Тайлант хугацаанд дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ руу тус тус илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2023 оны ногдол ашиг тараасан тухай тайлан
- 2023 оны санхүүгийн жилийн тайлан
- 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- 2023 оны компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан
- 2024 оны 1, 2, 3-р улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
- 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах болсон тухай мэдэгдэл
- 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол, хурлын тэмдэглэл,
- 2024 оны хагас жилийн санхүүгийн жилийн тайлан
- 2024 оны компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний хянан баталгаажилт
- 2024.07.19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол, хурлын тэмдэглэл,
- ХЭ-ийн хурал болон ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрүүдийг www.mse.mn сайтад байршуулсан.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндлэх бөгөөд оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах, баримтлах стратегийн бодлогын бичиг баримтыг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Одоогоор оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд компанийн ёс зүйн дүрэм болон шүгэл хүлээх журмыг батлан мөрдөж, ажиллаж байгаа.

Олон нийтэд нээлттэй, тогтмол хүргэх мэдээлэл хувьд: Үнэт цаасны зах зээл дээр нийтэд нээлттэй мэдээлэлд уг мэдээллийг олж авах асуудал “Үнэт цаасны тухай” хуулиар нийтэд тараахыг хориглоогүй мэдээллийг оруулж тооцно. Өөрөөр хэлбэл Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох дүрэм, журамд заасан олон нийтэд нээлттэй, тогтмол мэдээлэхийг үүрэг болгосон мэдээллүүд багтана. Түүнчлэн компанийн нийтэд нээлттэй мэдээлэлд дараах зүйлийг оруулна. Үүнд:

- Компанийн дүрэм түүнд орсон өөрчлөлтүүд
- Компанийн дотоод журам зааврууд
- Санхүүгийн тайлан баланс
- Компанийн болон санхүүгийн үйл ажиллагаа
- Тусгай зөвшөөрөл болон улсын бүртгэлийн гэрчилгээтэй холбогдсон баримт бичиг
- Аудитын тайлан
- Хуулиар хориглоогүй бусад

Оролцогч талуудаас мэдээллийг чөлөөтэй авах бололцоог хангах үүднээс мэдээлэл тараах доорх арга замыг компани авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр;
- Монголын Хөрөнгийн биржийн сайтаар дамжуулах;
- Өдөр тутмын сонин, радио, телевизор;
- Бусад хууль тогтоомжид заасны дагуу;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024.04.19-ний өдөр, ээлжит бус хурал 2024.07.19-ний өдрүүдэд тус тус болсон ба хурлыг “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу амжилттай зохион байгуулж, хурлын талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлсэн.

Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй 53 брокер, дилерийн компаниуд руу цахим хэлбэрээр 2024.04.19, 2024.07.19-ний өдрүүдийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичиг бүхий тараах материалыг хүргүүлж танилцуулсан.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

Оролцогч талуудтай хамтран ажиллах хөтөлбөрийн хүрээнд Хувьцаа эзэмшигч нарын “Үйлдвэртэй танилцах арга хэмжээ”-г 2024 оны 4-р сард, Ирээдүйн хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн явцтай биечлэн танилцах “Үйлдвэртэй танилцах аялал”-ыг 2024 оны 11-р сард тус тус зохион байгуулсан.



	Оролцогч талуудаас компанид мэдээлэл хүргэх хэлбэр:				
	<ol style="list-style-type: none"> 1. Цахим хэлбэрээр илгээвэл, info@buligaar.com гэсэн цахим хаягаар; 2. Шуудангаар илгээвэл, УБ хот, ХУД, 20-р хороо АШҮХ, Булигаар ХК-ийн байр, 3. Бичгээр хэлбэрээр ирүүлбэл, ТУЗ-ийн нарийн бичигт хүргүүлэх; 4. Биечлэн уулзах; 				
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл				
	Геополитикийн асуудлаас үүдэн дэлхийн болон дотоодын зах зээл дээр түүхий эдийн үнэ, тээврийн зардал ихээр өсөж, цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдэж, гадаад валютын ханшны өсөлт нь валютаар худалдан авдаг бүх бараа материал, үйлчилгээний үнэд нөлөөлж, улмаар компанийн ашигт ажиллагаа буурах, төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж, бидний үйлдвэрлэл үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөөд байгаа. Үүнээс гадна ижил төрлийн бүтээгдэхүүний хяналтгүй импортлогдон орж ирж, дотоодын зах зээл зарагдах болсон.				
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/				
	Нийт хувьцаа эзэмшигчийн тоо 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 400,212,000 үүнээс 5 ба түүнээс дээш хувийг 3 хувьцаа эзэмшигч буюу 88.11%-ийг дараах нэр бүхий хувьцаа эзэмшигчид нь эзэмшдэг болно. Үүнд:				
	<i>Нэр</i>	<i>Тоо ширхэг</i>	<i>Хувь</i>		
	А.Энхмэнд	156,630,000	39.14%		
	Б.Анхболд	145,996,000	36.48%		
	Б.Баянжаргал	50,000,000	12.49%		
	Бусад 849 хувьцаа эзэмшигч	47,586,000	11.89%		
	Нийт дүн	400,212,000			
	Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт гараагүй болно.				
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл				
	2024 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.				
9.	Ногдол ашгийн мэдээлэл				
	Компани нь 2023, 2024 онуудад санхүүгийн жилийн ашигт ажиллагаа зорилгод түвшинд хүрээгүй, Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадамжтай байх гэсэн Булигаар ХК-ийн ногдол ашгийн бодлогын 2.2. дахь хэсгийн 2.2.1 дэх заалтыг хангаагүй тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй болно.				
	<i>Он</i>	<i>Хувьцааны тоо /ширхэг/</i>	<i>Нэгж хувьцааны ногдол ашиг</i>	<i>Нийт ногдол ашгийн дүн</i>	<i>Ногдол ашиг тараалт</i>
	2020	400,212	-	-	
	2021	400,212	600 төг	240,127,200	ҮЦТХТ-өөр зуучлуулан 100% тараасан.
	2022	400,212,000	0.25 төг	100,053,000	Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй.
	2024	400,212,000	-	-	
	<i>Он</i>	<i>Нэгж хувьцааны ногдол ашиг (DPS)</i>	<i>Нийт ногдол ашгийн дүн</i>	<i>Ногдол ашиг тараалтын харьцаа (DPR)</i>	<i>Ногдол ашгийн өгөөж (Dividend yield)</i>
	2021	600 төг	240,127,200	62%	6%
	2022	0.25 төг	100,053,000	23%	2%
	Ногдол ашиг тараалтын харьцаа (DPR): Цэвэр ашгийн хэдэн хувийг ногдол ашиг болгон тарааж буйг илтгэнэ. Ногдол ашгийн өгөөж (Dividend yield): Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг нь нэгж хувьцааны ханишийн хэдэн хувийг эзэлж байгаагаар хэмжигдэнэ.				

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БУЛИГААР
ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА.

1. Монгол улсын эдийн засгийн гол тулгуур багана болсон Мал аж ахуйн салбар нь хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр, хөнгөн үйлдвэрийг түүхий эдээр хангаж байдаг уламжлалт салбар юм. Малаас гарах ашиг шим хүнс болон хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал нөлөөтэй. Тиймдээ ч Монгол Улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хүнсний хангамж, аюулгүй байдал” хөдөлгөөний нэг зорилтдоо мал сүргээ эрүүлжүүлэх гэж тусгажээ. Эндээс харахад “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд зөвхөн хүнс үйлдвэрлэл бус давхар хөнгөн үйлдвэрлэлийн салбар хөгжих боломжтой юм. Мал аж ахуйн гаралтай түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод, гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ гаргах томоохон зорилготой, салбараа түүчээлсэн хөнгөн үйлдвэрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ажиллалаа.



МАНАЙ БАГ 2024 ОНЫ ХОНКОНГИЙН APLF АРЬСАН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОВ.

2. 2024 оны 3-р сарын 19-өөс 21-ний өдрүүдэд БНХАУ-ын Hong Kong хотноо зохион байгуулагдсан Ази номхон далайн хамгийн том арьс ширний APLF 2024 үзэсгэлэнд салбараа төлөөлөн Булигаар ХК амжилттай оролцсон. Энэхүү үзэсгэлэн нь Ковид-19 цар тахлын хөл хорионоос хойш 5 жилийн дараа ийнхүү дахин нээгдэж, 40 дэх жилдээ зохион байгуулагдаж буйгаараа онцлог юм.

APLF-ийн үзэсгэлэн нь арьс шир, материал, дагалдах хэрэгсэл, загварын бизнесүүдийг нэг дор авчирдаг бөгөөд нүүр тулан уулзаж, мэндлэх боломж олгодог. Дэлхийн өнцөг булан бүрээс авчирдаг бөгөөд ингэснээр тэд шинэ түншүүд олж, шинэ хэрэглэгч эсвэл ханган нийлүүлэгчдийг олж, салбарын хөгжлийг урагшлуулах боломжтой болдог. Энэхүү үзэсгэлэнгээр хувцас загвар, амьдралын хэв маягт чиглэсэн хэд хэдэн үзэсгэлэнг зохион байгуулдгаас гадна байнга өөрчлөгдөж байдаг салбаруудын талаар зочдод болон үзэсгэлэнд оролцогчид эргэн тойрон дахь өөрчлөлтүүд болон ирэх улирлын төлөв байдлын талаар байнга мэдэж байх боломжтой.



БУЛИГААР ХК-ИЙН ТҮҮХТ 90 ЖИЛИЙН ОЙН БАЯР ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР БОЛЖ ӨНГӨРЛӨӨ.

3. Монгол Улсад Хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсэж хөгжсөн тэртээх 1934 онд анхлан “Булигаарын завод” нэртэйгээр байгуулагдаж үндэс сууриа тавьсан түүхт үйлдвэрийн 90 жилийн ойн баяр 2024.03.30-ны өдөр болж өнгөрлөө.

20-р зууны төгсгөлд хөгжил цэцэглэлтийнхээ оргил үед хүрч дэлхийд гялалзаж байсан Монголын арьс ширний салбарын ууган үйлдвэр болох “Булигаар” ХК нь нийгэм эдийн засаг, зах зээлийн уналт сэргэлтийн олон нугачаанд үндсэн үйл ажиллагаагаа орхигдуулалгүй амжилт бүтээлээр түүчээлэн өдгөө 2024 онтой золголоо.

Энэхүү бахдам түүх бол Булигаар ХК-ийн өнгөрсөн, одоо, ирээдүйн хөтөч болсон үеийн эвсэг хөдөлмөрч хамт олон та бүхний юутай ч эгнэшгүй итгэл сэтгэлийн үнэ цэнийн илэрхийлэл юм. Бидний хувьд 2019 оноос эхлэн “Булигаар” ХК-д менежментийн шинэчлэл хийн барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чиглэлд голчлон анхаарч алдагдаад байсан дотоодын зах зээлийг бүрэн хангаж экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Биднийг угтан байгаа он жилүүдийн хувьд Булигаар ХК тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж хүн болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулсан, өрсөлдөх чадвар болоод үнэ цэнээр баялаг Монгол арьсыг дэлхийн зах зээлд бэлтгэн нийлүүлэх алсын хараатайгаар хамт олныхоо нэгдмэл хүчин дор улам бүр өргөжин тэлсээр буйг дуулгахад таатай байна.



2024 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ. Монгол Улсад мөрдөгдөж буй Байгаль орчны хууль, тогтоомж, стандартын шаардлагуудын хэрэгжилтийг үнэлэх Байгаль орчны аудитаар 87 шалгуур үзүүлэлтийн хүрээнд 89 хувь гүйцэтгэлтэйгээр багц хуулийн нийцлийн аудитаар дүгнүүлэв.
5. НОГООН БАЙГУУЛАМЖ. Булигаар ХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдлээ. Энэхүү ажлын хүрээнд манай компанийн нийт ажилтнуудын оролцоотойгоор Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Инчон Мөрөөдлийн төгөл цэцэрлэгт хүрээлэнд 100 ширхэг хайлаас мод тарилаа. Түүнчлэн байгууллагын хэмжээнд ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэхээр зүлэгжүүлэлт хийв.




6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ. Орчны хяналт шинжилгээний дагуу хөрс, агаарын мониторинг хийгдэв.
 - Хөрсний шинжилгээг MNS3310:1991, MNS5850:2019, MNS6824:2020, MNS ISO11466:2007 стандартуудын үзүүлэлтийн дагуу микробиологи, хүнд металлыг тодорхойлох шинжилгээний 2 төрлөөр стандартын дагуу үзүүлэлтүүдийг хянаж зөвшөөрөгдөх хэмжээнд хэвийн үзүүлэлтийг хангав.
 - Агаарын шинжилгээг MNS4585:2016 стандартын дагуу үзүүлэлтүүдийг хянаж зөвшөөрөгдөх хэмжээнд хэвийн үзүүлэлтийг хангав.
 - Ундны усны шинжилгээг MNS9000:2018 стандартад нийцүүлэн хийсэн шинжилгээний үр дүнгээр унд эрүүл ахуйн усны стандартад нийцсэн цэвэр аюулгүй, нянгийн бохирдолгүй байсан.

7. Бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, шинэ технологи, арга барилыг байнга нэвтрүүлэн ашигладаг бөгөөд хуучин технологио эрчим хүч, зардал бага зарцуулдаг орчин үеийн тоног төхөөрөмжөөр шинэчлэх хөрөнгө оруулалтыг тасралтгүй хийсээр байна. Энэхүү ажлын хүрээнд:

- БНТУ-ын DEMAKSAN компанийн агрегат шүрших шугамыг үйлдвэрт шинээр суурилууллаа. Энэхүү суурилуулалтын ажлыг БНТУ-ын DEMAKSAN компанийн мэргэжилтэн SADIK SEZER нь манай компанид 2 дахь удаагаа 14 хоногийн хугацаатай томилолтоор ажиллалаа. Ажиллах хугацаандаа үйлдвэрт шинэ агрегат шүрших шугамын суурилуулалт туршилт тохируулгын ажилд гар бие оролцож, олон төрлийн туршилтуудыг Гүйцэтгэн боловсруулах цехийн ажилтнуудтай хамтран хийж гүйцэтгэлээ.



- Солонгос Улсын Rotoria брэндийн арьс шахах зориулалттай тоног төхөөрөмжийг суурилуулалт туршилт тохируулгын ажлыг Yurim Machinery компанийн мэргэжилтэн Choi Yongseog болон Park Youngbong нар нь манай компанид 7 хоногийн хугацаатай томилолтоор ажиллалаа.



8. Нийт ажилтнуудын эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор компанийн ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил тутам хамруулдаг. 2024 оны 3-р сард Эрхэт манал увидас эмнэлэгтэй хамтран 60 гаруй ажилтныг үзлэг шинжилгээнд хамруулсан. 2025 онд үзлэгт хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.
9. Ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжих зорилгоор 3 улиралд давхардсан тоогоор 40 ажилтанд 1,000 ширхэг эрдэс нөхөх бүтээгдэхүүн олгов.
10. Олон улсын Ахмадын баярын өдрийг тохиолдуулан Булигаар ХК-аас ахмад буурлуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Энэхүү арга хэмжээ нь сүүлийн 10 жилийн хугацаанд тасраад байсан. Ахмад настны тухай хуулийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан”-г байгуулж, сангийн хөрөнгөөс тухай хүндэтгэл үзүүлэх болон бэлэг дурсгалын зүйл зарцуулав.



Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Баттүшиг

Албан тушаал: “Булигаар” ХК-ийн
Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

**БУЛИГААР
ХК**
(Тамга/тэмдэг)
УУГС/ОС 8032285058 2009180

Овог, нэр: Д.Алтанцэцэг

Албан тушаал: “Сэрэлт дөл аудит” ХХК
аудитын компанийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

**СЭРЭЛТ
ДӨЛ АУДИТ
ХХК**
1115214463 УТ.60 (Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Сэлэнгэ

Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг: *Г. Сэлэнгэ*

Овог, нэр: Г.Цэпилжид

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичиг

Гарын үсэг: *Г. Цэпилжид*